

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД, МАЛ АЖ АХУЙН ЗАХ ЗЭЭЛ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл			
1	Төслийн нэр		МУ-ЕХны “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төсөл			
2	Санхүүжүүлэгч байгууллага		Европын холбоо			
3	Хэрэгжүүлэгч байгууллага		ХХААХҮЯ			
4	Хэрэгжүүлэх хугацаа		2008.01.01-2012.12.31			
5	Төслийн зорилго		Монгол Улсын Засгийн Газарт хөдөө аж ахуйн салбарын үйлчилгээг сайжруулах замаар хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулахад нь дэмжлэг үзүүлэх.			
6	Төслийн зорилт		Үр ашигтай, зах зээлийн баримжаат мал аж ахуйн салбарыг буй болгох замаар эдийн засгийн үндэс нь мал аж ахуй болсон хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулах.			
7	Зардал (сая.төг)	Төсөв (тайлант оны)	128766,20 мян.төг			
		Гүйцэтгэл (тайлант оны)	120799,51 мян.төг			
	Санхүүгийн талаар		Санхүүгийн тайланг Төсөл хэрэгжүүлэх баг/ТХБ/-ийн гаргаж өгсөн тайланг үндэслэв. Цалинд - 70,6сая.₮, ашиглалтын зардалд - 38,4сая.₮, 0,8сая.₮, гадаад, дотоод томилолт - 5,1 сая.₮, эд хогшил худалдаж авахад-3,8 сая.₮, бусад зардалд 1,9 сая.₮ буюу, нийт 120,8 сая.төг зарцуулжээ. 7,9 сая.₮-ний бүртгэлжүүлэлтийн программ орж иргээгүй хойшлогдсон байна.			
8	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	зорилтууд	Дүн	I	II	III
		Биелэлт % 80,0 %	3	78,0	82,0	80,0
9	Хөтөлбөрийн хэрэгжилт		80,0% буюу “Хангалттай” хэрэгжиж байна.			
10	Үр дүн:1. Хөдөө аж ахуйн салбарын болон гамшгийн эрсдлийг бууруулах институтын чадавхийг дээшлүүлэх.		Үр дүн 1.1: Мал аж ахуйн салбарт мөрдөж байгаа хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох. Төслөөс “МАН-н салбарын хууль эрх зүйн эмхтгэл” номыг шинээр нэгтгэн ХЗДХЯ-ны Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр хянуулж хэвлүүлж, холбогдох яам, агентлаг болон нийт 75 сум, 180 хувийн мал эмнэлэг, үржлийн газруудад хүргүүлж, эдгээр байгууллага, хүмүүс ажлын хэрэгцээнд эрх зүйн баримт бичиг болгон ашиглаж байна. Сонгогдсон аймаг, нийслэлийн хүрээнд малын байршил нутаг болон малыг бүртгэлжүүлэх ажлын загвар журмын төслийг боловсруулсан. Мөн мал эмнэлгийн албанд 2007 онд ДАЭМБ-ын экспертын багаас хийсэн үнэгээний “Монголын мал эмнэлгийн засаглалын арга хэрэгсэл, гүйцэтгэл, хэтийн төлөв, стратеги” гэсэн тайланг орчуулжээ. Уг баримт бичгийг манай улсын МЭА-ны тогтолцоог ОУ-ын жишигт нийцүүлэх гол баримт материал болсон байна. Төслөөс МУ-д мөрдөгдөж буй “Мах махан			

		<p>бүтээгдэхүүн Эрүүл ахуйн аюулгүйн үндсэн шаардлагууд” MNS 5023:2001, “Үхэр өсвөр үхэр, адууны өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах” MNS 11115:2007 зэрэг стандартуудыг англи хэл рүү орчуулж яамны холбогдох газар, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, байгууллага, иргэдэд өгч ажиллаж байна.</p> <p>Тус төсөл дээрх ОУ-ын болон үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг харьцуулан судалж, улмаар салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чухал материал бүрдүүлж байгаа болно. Төсөл УМЭАЦГЛ, МХЕГ зэрэг байгууллагуудын эрх зүйн хүрээг судалж, SWOT шинжилгээг хийж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан. МХЕГ-ын хийлгэсэн (өөр төслөөр) SWOT шинжилгээнд анализ хийж үзэхэд: Тус газар нь малын эрүүл мэндийн тандах судалгааны үр дүнгийн мэдээлэлгүй мөртлөө ОУ-ын сертификат дээр ажилтнууд нь гарын үсэг зурдаг нь эрх зүйн хувьд зөрөөтэй бөгөөд ДАЭМБ-ын зөвлөмж, шаардлагатай нийцэхгүй болохыг тогтоожээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-78,0%</p>
	<p>Үр дүн:2. Малын эрүүл мэндийг сайжруулах.</p>	<p>Төслөөс нийлүүлэх тоног төхөөрөмжийг хүлээн авагчдыг шалгаруулах журам, дүрмийг боловсруулж, 12 багц тоног төхөөрөмжийн(3,4 сая.евро) тендерийн техникийн үнэлгээнд оролцож, аймаг, сум, нийслэлийн 20 нэгжид 2009 онд 609,4 мян.еврогийн үнэ бүхий тоног төхөөрөмж нийлүүлжээ. Бруцеллэз, боом, галзуу зэрэг тэргүүлэх малын өвчний мэдээлэл дамжуулах загвар хувилбарыг боловсруулж, зорилтод аймгуудад өгсөн. Мал эмнэлгийн эмийн зааврын шинэчилсэн эмхтгэл, мөн нийлүүлж буй тоног төхөөрөмжийн гарын авлага зэргийг орчуулж, сургалт хийв. МЭҮГ-т мал эмнэлгийн эпидемиологи, мал бүртгэлжүүлэлтийн нэгжийг байгуулах, улмаар малын өвчний мэдээллийг шуурхай болгох, боловсруулах, дүн шинжилгээ хийх, холбогдох газруудыг мэдээллэр хангах боломжийг бүрдүүлэх зорилгоор нийт 8 нэрийн 22,7сая.₮-ийн тоног төхөөрөмж олгож, дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-82,0</p>
	<p>Үр дүн:3. МAA-н бүтээгдэхүүн ба</p>	<p>Төслөөс анх удаа мал ба малын байршил нутгийг түүний бүртгэлээр нь эргэн тогтоох ажлыг хийж эхэлсэн бөгөөд тусгай программ хангамж нийлүүлэх тендер зарлан Испани улсын INKOA компани нийлүүлэх болсон. Булган, Сэлэнгэ, Төв аймгийн 4 сум, УБ хотын 5 дүүргийн түвшинд мал болон малын байршил нутгийн хувийн мал эмнэлгийн нэгжийн малын эмч нарын оролцоотой явуулсан. Уг бүртгэл нь цахим хэлбэрийн малын бүртгэл мэдээллийн сангийн суурь үзүүлэлт болох юм. Тус яамны хүрээнд МAA-н салбарын маркетингийн асуудлыг нэгтгэн зохион байгуулах “Маркетингийн хороо”-г байгуулсан. Тус хорооны ажлын гол үр дүнгийн нэг нь маркетингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ТББ</p>

		<p>болон төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлж байна. Энэхүү хороонд 21,2 сая₮-ийн тоног төхөөрөмж олгожээ. ЗЗМС байгуулах ажлын хүрээнд МАА-н гаралтай 19 нэрийн үндсэн бүтээгдэхүүний үнэ ханшийн мэдээг төслийн аймгууд болон УБхотын зах зээлээс цуглуулж интернет болон Монголын үндэсний радиогоор 7 хоног тутам, “ХАА-н маргааш” сонинтой гэрээ хийж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөний материалыг хэвлүүлж байна. Үүний үр дүнд: Малчид, фермерүүд, ЖДҮ-лэл эрхлэгчид мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв хүлээн авах боломжоор хангагдаж байна. Төслөөс нядалгааны хонийг ангилахад болон эрүүл ахуйн шаардлага хангасан үйлдвэрлэлд тавигддаг үндсэн шалгууруудыг оруулсан 2 зурагт хэвлүүлсэн. Малын хадлан, тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг 11 сард оройтож ирсэн тул тэжээл үйлдвэрлэх талбайн туршилт явуулах ажил хийгдээгүй. Төслөөс 18 чиглэлээр 356 хүнийг хамруулсан сургалт, семинар зохиолн байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80,0%</p>
	Бусад үйл ажиллгаа:	<p>Төслийн хүрээнд: Хувийн хэвшлийн ААН, байгууллага, иргэдэд нийлүүлж буй тоног төхөөрөмжийн орон нутгийн үнийн 30-60%-ийг эргэн төвлөрүүлэх зарчмаар “Эргэлтийн сан” байгуулж, үйл ажиллагааны дүрмийг боловсруулсан нь сонгогдсон аймаг, орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчид, малчид, хувийн малын эмч мэргэжилтнүүдэд ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл өргөжүүлэхэд ихээхэн чухал арга хэмжээ болсон байна. Малын эрүүл мэндийн хяналт, мал бүртгэлжүүлэлтийн чиглэлээр ЕХ-ны гишүүн –Латви улсад 11 тухайн аймаг, нийслэлийн хувийн малын эмч, ММХолбоо, ММЭХолбоо, ТХБагийн төлөөлөл хүнийг оролцуулсан танилцах, туршлага судлах аялалыг зохион байгуулсан. Төслийн зорилго, зорилт, хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгасан вебсайтыг шинээр нээж ажиллуулж байна.</p>
11	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Тус төсөл үндсэн 3 үр дүн, 11 дэд үр дүнгийн хүрээнд 34 үйл ажиллагаа, 150 гаруй дэд үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд тайлант 2009 оны байдлаар төслийн нийт ажлын 40%-ийг гүйцэтгэсэн байгаа нь зохих түвшинд байгааг харуулж байна. Төслийн багийн хяналтаас гаднах хүчин зүйлүүдээс шалтгаалж төслөөс нийлүүлэх тоног төхөөрөмжийн зарим хэсэг нь хугацаанаасаа хожимдож ирснээс болж, үүнтэй холбогдох 17 үйл ажиллагаа(мэргэжлийн сургалт, семинар) дараа онд шилжижи хийгдэхээр болсон байна. Мөн гахайн ханиад гарсантай холбогдож ЗГ-аас гаргасан хорио цээрийн улмаас 4 сургалт, семинар мөн 2010 онд хийгдэхээр хойшлогдсон байна. УМЭАЦТЛ-д орчин үеийн өндөр мэдрэмжит “Масс спектрометр болон хийн хроматограф”</p>

		багажийн хослол төхөөрөмж нийлүүлэгдсэнээр манай улсын хэмжээнд анх удаа мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд эм, хиймийн бодисын үлдэгдэл тодорхойлох, баталгаажуулах шинжилгээг найдвартай хийх нөхцөл бүрдэж байна. Төслийн 2009 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд “Хангалттай” үнэлгээг өгч байна.
12	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Төслөөс оруулж ирж буй тоног төхөөрөмжүүдийг ашиглах зааврыг танилцуулах, сургалтуудыг үргэлжлүүлэх. 2. Зах зээлийн мэдээллийн системийг сонгогдсон аймгуудад хэрэгжүүлэх. 3. Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох. 4. Эргэлтийн сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА